



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/20

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 30.2.1, 48 дугаар зүйлийн 48.2.3, 48.2.4, 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Баянтээг багт хогийн менежментийг хэрэгжүүлэх ажлын тендерийг 10.560.000 (арван сая таван зуун жар) төгрөгөөр "Хамтын хүч" бүлэгээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

022411039



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А121

Нарийнтээл сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дүгээр зүйлийн 30.1, 30.2.1, 48 дүгээр зүйлийн 48.2.3, 48.2.4, 48.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих Сумын төвд хогийн менежментийн ажлыг хэрэгжүүлэх тендерийг 18.482.600 (арван найман сая дөрвөн зуун хорин зургаа) төгрөгөөр "Эвийн хүч" бүлэгээр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хяналт тавьж гэрээ байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Ичинноров)-д даалгасугай.

3.Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

№ 622411041

D.Mv.Doc.A4Zahirami /ZD/



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/22

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Сумын 2024 оны төсөв батлах тухай" ээлжит 15 дугаар хуралдааны 15/07 дугаар тогтоолыг ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын ихэнх нутгаар цас орж хүйтэрч байгаатай холбогдуулан зудын эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс Арвайхээр дэхь, аймгийн нөөцийн агуулахаас 500 ширхэг ногоон тэжээл, Улсын нөөцийн 136-р салбарын 048-р цэгээс 25 кг-тай 1000 шуудай хивгийг тээвэрлэн татан авч малчдад дэмжлэг болгон олгох зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг эрсдлээс хамгаалах сангаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411043

Нарийнтээл сумын Засаг даргын 2024
оны 02 дүгээр сарын 04 ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Матерал	ширхэг	Ширхэгийн үнэ	Нийт үнэ
1	Ногоон тэжээл Арвайхээрээс тээвэрлэх зардал / Автомашин/	500	3000	1,500,000
2	Улсын фонтоос хивэг зөөх /Ачигч/	1000	280	280,000
3	Арвайхээрийн фонтоос ногоон тэжээл ачих / Ачигч/	500	400	200,000
Нийт:				1.980,000

_____ооо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/23

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ахмадын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 15.5, 14.5.2, 14.6, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн "Сумын 2024 оны төсөв батлах тухай" ээлжит 15 дугаар хуралдааны 15/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ахмад настнуудын мод, бут тарьж ургуулах, арчлах үйл ажиллагааны зардалд 1.200.000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг эрсдэлээс хамгаалах сангийн зохих зардлаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

G22411045

D:\My Doc\A4Zahirami\ZD\

Нарийнтээл сумын Засаг даргын 2024
оны 09 дүгээр сарын 07 ны өдрийн А/23
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Ажлын нэр	Нийт сарын тоо	сарын хөлс	Нийт хөлс
1	Мод арчилгаа	12	100,000	1,200,000
Нийт:				1,200,000

_____ооо_____



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/24

Нарийнтээл сум

Г Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн "Шар хад", "Навчтын ам" гэдэг газарт өвөлжиж байгаа малчин Р.Нэргүй, А.Чимэдцэрэн нарын малд 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр хонь ямааны цэцэг өвчний шинж тэмдэг илэрсэн тул тухайн нутаг дэвсгэрт 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн тодорхойгүй хугацаагаар хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт байгаа малтай өрхүүдийн малд тандалт шинжилгээ хийж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч Д.Бямбадолгор, Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч П.Төмөртоогоо, 2 дугаар багийн Засаг дарга Б.Базарсад нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Батсүх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411047



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А125

Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт иргэдийн эрүүл мэндийг хамгаалах үйлст үр дүнтэй ажиллаж байгаа эрхлэгч их эмч С.Баярмаад мэргэжлийн мэдлэг, үр чадвараа дээшлүүлэхэд 1.000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411049



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/26

Нарийнтээл сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн З.Дарьбазарын нөхөр Б.Энхбаатарын эмчилгээний зардалд зориулан 400,000 (дөрвөн зуу) мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411051



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/27

Нарийнтээл сум

Мал амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.8.1, 9.8.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжээнд мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын ажлыг 2024 оны 02 дугаар сарын 19-нөөс 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Багийн малчид, иргэдэд дархлаажуулалтын ажлын зар, мэдээллийг цаг тухайд нь хүргэж, хариуцсан багийн мал сүргийг тогтоосон хугацаанд бүрэн хамруулахыг 2 дугаар багийн Засаг дарга Б.Базарсад, 4 дүгээр багийн Засаг дарга Ц.Мөнх-Эрдэнэ нарт даалгасугай.

3.Хонь, ямааны цэцэг өвчний вакцинжуулалтын арга хэмжээг хийж гүйцэтгэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.

4.Хонь, ямааны цэцэг өвчний вакцинжуулалтанд зарцуулах хөрөнгийн зардлыг малын тоо толгойн албан татварын хөрөнгөөс зарцуулахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д зөвшөөрсүгэй.

5.Хонин сүрэгт хийх мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, ажлын явц, үр дүнд хяналт тавьж, дүнг танилцуулахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16 ны өдрийн 1127 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ХОНЬ, ЯМААНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Бараа материалын нэр	Явах км	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
Бумбат суварга БГБХН / Баянтээг баг/						
1	A-92	300	Литр	120	2660	271,200
Бумбат-Ур БГБХН /Цагаан-Овоо баг/						
2	A-92	100	литр	40	2660	206,400
Нийт дүн						477,600

_____оо_____

Нарийнтээл сумын Засаг даргын 2024
оны 09 дугаар сарын 16 ны өдрийн 1127
дугаар захирамжийн хавсралт



МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ХОНЬ, ЯМААНЫ ЦЭЦЭГ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүдэд: П.Төмөртоогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Д.Цэцгээ (Малын их эмч)

Р.Бат-Эрдэнэ (Малын их эмч)

Г.Батсүх (Малын их эмч)

Б.Базарсад 2 дугаар багийн Засаг дарга

Ц.Мөнх-Эрдэнэ 4 дүгээр багийн Засаг дарга

Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Г.Наранбаатар (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Д.Сугарсүрэн (МЭХЦХЦэгийн малын эмч)

Г.Гантогтох (МЭХЦХЦэгийн ариутгагч)

Ц.Мөнхдорж (МЭХЦХЦэгийн ариутгагч)

А.Батмөнх (жолооч)

Н.Цэнд-Аюуш (жолооч)

О.Энх-Амгалан жолооч

А.Пүрэвдавга жолооч

Ц.Цэвээнсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны
мэргэжилтэн)



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/28

Нарийнтээл сум

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд зарим арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 11 дүгээр зүйлийн 11.3.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Улсын Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт их хэмжээний цас орж, цасан шуурга тавьж малчид, иргэдэд их хэмжээний хохирол учирч болзошгүй байгаа тул 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн сумын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, хор уршгийг арилгах, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг уялдуулан зохицуулах үүрэг бүхий сумын Шуурхай штабын үйл ажиллагааг эрчимжүүлэн шаардлагатай хэрэгслээр хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга, Шуурхай штабын дарга (Б.Ичинноров)-д үүрэг болгосугай.

3.Цаг уурын байгууллагын мэдээгээр 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн цас орж хүчтэй салхи, цасан болон шороон шуурга шуурч, үзэгдэх орчин хязгаарлагдаж, зам даваа, гүвээнд хальтиргаа гулгаа үүсэж, хүйтний эрч эрс чангарах тул иргэд, малчид болзошгүй эрдслээс урьдчилан сэргийлж, малаа ойрын бэлчээрт хариулах, бага насны хүүхдийг малд явуулахгүй байх, онцын шаардлагагүй бол хол, ойрын замд гарахгүй байхыг үүрэг болгосугай.

4.Цаг агаарын аюулт үзэгдлийн талаарх мэдээллийг малчид, иргэдэд тогтмол хүргэж ажиллахыг сумын цаг уурын техникч (Д.Хорлоо), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий Боловсролын сургуулийн сурагчдыг болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч (Ц.Энхцэцэг, Д.Чимэгмаа), Ерөнхий Боловсролын сургуулийн захирал (Б.Түмэндэмбэрэл, Б.Цэрэндолгор) нарт үүрэг болгосугай.

6.Хүйтний эрч эрс чангарч байгаатай холбогдуулан уурын зуухнуудын түлшний нөөцийг бүрдүүлэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг дулаанаар хангах үйл ажиллагааг сайжруулан, бэлтгэл бэлэн байдлаа хангаж ажиллахыг "Баянтээг" ХК, "Нутгийн буян" ХХК-ын удирдлагуудад үүрэг болгосугай.

7.Улсын Онцгой комисс, аймгийн Онцгой байдлын газраас болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор явуулж буй мэдээ мэдээллүүдийг иргэдэд тогтмол түгээж ажиллахыг Соёлын төвийн эрхлэгч (М.Ганжаргал)-д үүрэг болгосугай.

8.Эрүүл мэндийн төвүүд хол, ойрын дуудлаганд явахдаа бензин, шатахууны нөөц бүрдүүлэн, тээврийн хэрэгслүүдийн найдвартай, бүрэн бүтэн байдлыг хангаж, өдрийн гэрэлтэй цагаар тээврийн хэрэгслийн хурдыг тохируулан аюулгүй байдлаа хангаж сумын шуурхай штабыг мэдээллээр тогтмол ханган ажиллахыг Эрүүл Мэндийн төвийн эмч (М.Долгормаа, Г.Билгүүн) нарт үүрэг болгосугай.

9.Мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, өвс, тэжээлийн нөөцийн судалгаа, малын хорогдлын мэдээг гаргаж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор), Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Д.Энхжин) нарт үүрэг болгосугай.

10.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Хэсгийн төлөөлөгч (У.Мягмарнасан), Засаг даргын орлогч (Г.Батсүх), Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (С.Баасандулам) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

022411056



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/29

Нарийнтээл сум

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 2 дугаар багийн "Шар хад", "Навчтын ам", "Эргүү", "Бор хошуу", "Хараат ягааны ихэр"гэдэг газарт өвөлжиж байгаа малчин Р.Нэргүй, Р.Жаргал, Р.Мандах, А.Чимэдцэрэн, Д.Төрмөнхийн малд малын гоц халдварт хонь ямааны цэцэг өвчин илэрсэн тул 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 30 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2.Хорио цээрийн дэглэмийн үед ажиллах мэргэжлийн багийг нэгдүгээр хавсралтаар, хөдөлгөөнт эргүүлээр гарах жижүүрийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хорио цээрийн бүсэд хийгдэх халдваргүйтгэл, дархлаажуулалтыг чанартай зохион байгуулахыг Мал эмнэлэгийн үйлчилгээний нэгжийн эмч (Д.Цэцгээ)-д үүрэг болгосугай.

4.Малын гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчин тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах хөдөлгөөнт эргүүл, техник хэрэгсэл, хүн хүчийг дайчлан гаргаж, холбогдох хууль, журмыг мөрдүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож ажиллахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д тус тус даалгасугай.

5.Голомтын бүсэд томилогдон ажиллаж байгаа гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн албан хаагчид, голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн

тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хяналтанд авах, шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлэх, эрсдэлтэй бүлгийн судалгааг гаргаж ажиллахыг Баянтээг багийн Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч (Г.Билгүүн)-д үүрэг болгосугай.

6.Хорио цээрийн бүсийн хүн амын хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиулж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч (У.Мягмарнасан)-д үүрэг болгосугай.

7.Голомтын бүсэд малын шилжилт хөдөлгөөн, нүүдэл хийх, голомтын бүсээс мал малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн гаргахыг түр хугацаагаар зогсоож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-д үүрэг болгосугай.

8.Малчид, иргэд, олон нийтэд хонь, ямааны цэцэг өвчний талаарх мэдээллийг хүргэж урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага, цахим мэдээллээр хангаж ажиллахыг тархвар зүйн (П.Төмөртогоо), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

9.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Бямбадолгор) нарт тус тус үүрэг болгосугай.

10.Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн "Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай" А/24 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

022411057



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/30

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн "Зорилтод жил зарлах тухай" 23/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Цахим шилжилтийг эрчимжүүлэх жилийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Ичинноров (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Баасандулам (Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

Б.Базарсад (2 дугаар багийн Засаг дарга)

О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)

Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)

Б.Түмэндэмбэрэл (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)

Б.Цэрэндолгор (Баянтээг багийн ЕБС-ийн захирал)

Ц.Энхцэцэг (Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын эрхлэгч)

Д.Чимэгмаа (Баянтээг багийн Хүүхдийн цэцэрлэг)

М.Долгормаа (Эрүүл мэндийн төвийн эмчлэгч эмч)

М.Ганжаргал (Соёлын төвийн эрхлэгч)

Б.Ганцэцэг (ЕБС-ийн мэдээлэл технологийн багш)

Т.Батдулам (Насан туршийн боловсролын нэгжийн багш)

Нарийн бичгийн дарга: Н.Мягмаржав (Газрын даамал)

2.Зорилтод жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар ханган ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Ичинноров)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР



№ 022411059



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/31

Нарийнтээл сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 48.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Малын гоц халдварт өвчний зардлыг шийдвэрлэх" үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүд: О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)

М.Гандолгор (Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн

менежер)

Д.Данаасүрэн (Хувиараа бизнес эрхлэгч)

Нарийн бичгийн дарга: Ц.Сайнбилэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2.Бараа ажил үйлчилгээг худалдан авахдаа худалдан авах ажиллагааны журмын дагуу ажиллаж чанарын шаардлага хангасан бараа нийлүүлэхийг үнэлгээний хорооны дарга (Д.Бямбадолгор)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411061



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/32/

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд цас их орж зудын нөхцөл байдал үүсч малчдын нөхцөл хүндэрсэн тул малын тэжээлийн дэмжлэг болгон 4.788.000 (дөрвөн сая долоон зуун наян найман) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг эрсдлийн сангаас гаргахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Г.Наранхүү)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411062

Нарийнтээл сумын Засаг даргын 2024
оны 09 дугаар сарын 29 ны өдрийн 132
дүгээр захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1.	Өвс	266	18000	4.788,000
Нийт дүн				4.788,000

_____оо_____



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/32

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын"-ын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус суманд цас их орж зудын нөхцөл байдал үүсч малчдын нөхцөл хүндэрсэн тул малын тэжээлийн дэмжлэг болгон 7.398.000 (долоон сая гурван зуун ерэн найман) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

022411065



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/34

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилт жилийн ажлын хүрээнд зохион байгуулж явуулсан "Хуванцар савнаас татгалзъя" аяны зардалд 1.105,000 (нэг сая нэг зуун таван мянган) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

022411067

D My Doc A4Zahirami /ZD/



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/35

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйл, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын төв, Баянтээг баг, Арвайхээр суманд зохион байгуулагдсан Ахмадын золголтын арга хэмжээний зардалд 3.633,500 (гурван сая зургаан зуун гучин гурван мянга таван зуу) төгрөгийг зарцуулж тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг нягтлан бодогч (Ц.Сувд-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

622411069

Нарийнтээл сумын Засаг даргын 2024
оны 02 дугаар сарын 29 ны өдрийн А/35
дүгээр захирамжийн хавсралт



АХМАДЫН ЗОЛГОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Езвэн	ш	100	2700	270.000
2	Гурван хос езвэн	ш	3	16000	16.000
3	Суурь езвэн	ш	1	17000	17.000
4	Хэвийн боорцог	ш	25	44000	110.000
5	Айраг	л	65	7000	455.000
6	Тос	кг	6	38000	228.000
7	Ууц	кг	60.5	11000	665.500
8	хоол	ш	50	10000	500.000
9	Хоол	ш	6	12000	72.000
10	Бэлэг	ш	100	13000	1.300.000
	Дүн				3.633.500

ооо